



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТЭМДЭГ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТОХИОЛДОЛД ЖОЛООЧ АВТОМАШИН АЧИЛТЫН ТӨЛБӨРИЙГ БУЦААН ГАРГУУЛАХ БОЛОМЖТОЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: BVerwG 3 C 10.15

Шүүхийн шийдвэрийн огноо: 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр

Шийдвэрийн агуулга: Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хэргийн бодит нөхцөл байдлыг дахин тодруулах шаардлагатай гэж үзэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх рүү буцааж шийдвэрлэв.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч автомашинаа байрлуулахдаа дараагийн өдөр нь болох олон нийтийн арга хэмжээний улмаас түр хугацаанд автомашин зогсохыг хориглосон замын тэмдэгтэй хэсэгт байрлуулсан байжээ. Хариуцагч (цагдаагийн албан хаагч) нь автомашин ачилт дуудаж, машиныг холдуулсан ба ачилтын 125 еврогийн төлбөрийг нэхэмжлэгчээс нэхэмжилсэн. Нэхэмжлэгчийн зүгээс замын тэмдэг нь шууд танигдахуйц, нүдэнд ил байрлаагүй, автомашин байрлуулахыг хориглосон хязгаарлалт нь нийтэд урьдчилан мэдэгдсэн байх хууль зүйн шаардлагыг хангаагүй тул төлбөрийг хууль бус гэж үзэн маргасан байна.

Анхан болон давж заалдах шатны шүүхүүд нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгчийг автомашинаа байрлуулахдаа зайлшгүй эргэн тойрноо ажиглах үүрэгтэй гэж үзсэн бөгөөд хэрэв нэхэмжлэгч үүргээ биелүүлсэн бол зогсохыг хориглосон тэмдгийг харах боломжтой байсан гэж дүгнэжээ. Гэсэн хэдий ч шүүх замын тэмдгийг ямар өндөрт, ямар чиглэлд байрлуулсан талаарх нөхцөл байдлыг тодорхой дүгнэлгүй орхисон байна.

Харин Холбооны захиргааны хэргийн шүүх давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, замын тэмдэг бодитоор жолоочид харагдах боломжтой байсан эсэх зэрэг хэргийн бодит нөхцөл байдлыг дахин нарийвчлан тогтоолгохоор хэргийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд буцаан шилжүүлсэн байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Холбооны захиргааны хэргийн шүүхээс:

1. Давж заалдах шатны шүүх зогсохыг хориглосон тэмдгийг байршуулахад замын хөдөлгөөнийг шууд зохицуулсан тэмдгээс бага шаардлага тавигддаг талаар зөв дүгнэсэн. Харин жолоочийг зогсохын хориглосон тэмдэг байгаа эсэхийг зайлшгүй шалгаж, олж харах үүрэгтэй гэж үзсэн нь үндэслэлгүй.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.bverwg.de/en/060416U3C10.15.0>, (Сүүлд үзсэн: 2025.12.23).



2. Шүүхийн тогтсон жишгийн дагуу, зогсохыг хориглосон замын тэмдэг нь хөдөлгөөний бусад хязгаарлалт, зааварчилгааны адил Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн² 35 дугаар зүйлийн 2 дахь өгүүлбэрт заасан захиргааны ерөнхий акт юм. Иймээс захиргааны акт чиглэгдсэн этгээдэд мэдэгдсэн мөчөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Замын хөдөлгөөний дүрмээр замын хөдөлгөөний тэмдгийг байрлуулснаар мэдэгдсэнд тооцдог. Хэрэв замын хөдөлгөөний тэмдгийг жолооч “хурдан, түрхэн зуур харахад” ч анзаарч, таних боломжтой байдлаар байрлуулсан бол тухайн тэмдгийг бодитоор харсан эсэхээс үл хамааран бүх жолоочид хамаатай.
3. Давж заалдах шатны шүүх жолоочид автомашинаа байрлуулсны дараа орчноо ерөнхийд нь ажиглахаас гадна зайлшгүй нарийн шалгах үүрэгтэй гэж үзэж, улмаар “шаардлагатай тохиолдолд” авто машинаа байршуулсан газраас хоёр чиглэлд тодорхой зайд алхаж, автомашин зогсохыг хориглосон эсэхийг шалгах ёстой байсан гэж дүгнэсэн. Энэхүү “шаардлагатай тохиолдолд” гэж дүгнэсэн нь жолоочийн үүргийг хэтрүүлэн тайлбарласан байна.
4. Түүнчлэн жолоочийг ойр орчноо нарийн шалгах үүрэгтэй гэж үзсэн тохиолдолд “зогсохыг хориглосон” тэмдэг хангалттай харагдаж байсан гэх хэргийн бодит нөхцөл байдал хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хангалттай тогтоогдсон гэж дүгнэх боломжгүй болно.
5. Давж заалдах шатны шүүхийн тогтоосноор, замын хэсэг нь ойролцоогоор 90–100 метрийн урттай байсан. Уг хэсэгт нийт зургаан ширхэг “зогсохыг хориглосон” тэмдэг байрлуулсан бөгөөд замын хоёр талд тус бүр гурван тэмдэг байсан байна. Эдгээрээс дөрөв нь замын хоёр талын уулзварт, үлдсэн хоёр нь замын дунд хэсэгт, өөрөөр хэлбэл замын уулзваруудаас 45–50 метрийн зайд байрласан байжээ. Автомашиныг ачуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн цагдаагийн албан хаагч болон замын хөдөлгөөний тэмдгүүдийг байрлуулж, зогсоолын зөрчлийг мэдэгдсэн этгээдийн мэдүүлснээр, замын тэмдгийг “илт танигдахуйц” байдлаар байрлуулсан байсан гэжээ. Үүнд тулгуурлан давж заалдах шатны шүүх жолоочийг эргэн тойрноо ажигласан бол замын тэмдгийг харах боломжтой байсан гэж үзсэн.
6. Гэвч давж заалдах шатны шүүх нэг талаас “эргэн тойрноо ажигласан бол” зогсохыг хориглосон тэмдгийг харах боломжтой байсан гэж үзсэн атлаа, нөгөө талаас жолоочид тодорхой шалтгаангүйгээр орчин тойрноо нарийн шалгах үүрэгтэй гэсэн шаардлагыг тавьсан. Иймд давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчид “зогсохыг хориглосон” тэмдэг харагдахуйц байсан гэж дүгнэсэн нь бодит байдал дээр “нэхэмжлэгч орчин тойрноо илүү нарийвчлан шалгасан бол тэмдгийг олж харах байсан” гэсэн ойлголтод хүргэж байна.
7. Гэтэл үүнээс өмнөх, зайлшгүй тодруулах шаардлагатай суурь асуулт болох “тухайн нөхцөл байдалд ийнхүү илүү нарийн шалгалт хийх тодорхой шалтгаан үнэхээр байсан эсэх?” асуудалд хариулт өгөөгүй үлдсэн байна. Хэрэв ийм шалтгаан байгаагүй бөгөөд давж заалдах шатны шүүх энэ талаар ямар нэгэн бодит нөхцөл байдлыг тогтоогоогүй бол зогсохыг хориглосон тэмдэг харагдахуйц байсан гэх дүгнэлт нь үндэслэлээ алдана. Иймд шүүхийн шийдвэрийн үндэслэл хэсэгт автомашиныг ачих ажиллагааг явуулсан цагдаагийн албан хаагч болон замын хөдөлгөөний тэмдгүүдийг байрлуулсан этгээдийн бичгээр өгсөн мэдүүлгийг иш татсан ч, эдгээр мэдүүлэг нь замын тэмдэг нүдэнд ил харагдахуйц байх шаардлага болон жолоочид орчин тойрноо шалгах үүрэг ногдох эрх зүйн нөхцөлийг зөв

² Administrative Procedure Act (1976), section 35, https://www.bmi.bund.de/SharedDocs/downloads/EN/gesetztestexte/VwVfg_en.pdf?blob=publicationFile&v=3, (Сүүлд үзсэн: 2025.12.25).



ойлгосон үндэслэл дээр суурилсан эсэхийг тодруулах хүртэл хангалттай гэж үзэх боломжгүй юм.

8. Иймээс хэргийг эцэслэн шийдвэрлэхийн тулд, тухайн хэрэгт “зогсохыг хориглосон” тэмдгүүдийг хэрхэн, ямар байдлаар байрлуулж, суурилуулсан нь тэдгээрийн харагдах байдалд хэрхэн нөлөөлсөн, хуульд заасан журмын дагуу нийтэд мэдэгдсэн эсэхийг тодруулахад нэмэлтээр бодит нөхцөл байдлыг тогтоох ажиллагаа зайлшгүй шаардлагатай гэж тайлбарлажээ.

---o0o---